



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН
ТУШААЛ**

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 4/41

Дэлгэрхаан сум

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1.1 дэх заалт, Эмнэлгийн тусламжийн үйлчилгээний тухай хуулийн 4.1 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/502 тоот тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багт үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ

О.Тогтог

О.БАТБАЯР

Өдрийн эмчилгээ үзүүлэх журам

Зорилго нь: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг багасгах, өвчтний сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.

Нэг. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний зохион байгуулалт

1. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ гэдэгт үйлчлүүлэгчийг өдрийн цагаар СЭМТөвөөр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
2. Өдрийн эмчилгээг хийхдээ "Эмнэлгийн мэргэжилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллана.
3. Өдрийн эмчилгээнд эмчийн бичсэн жороор гэрээр ууж хэрэглэх эм, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ орно.
4. СЭМТөвөөс өдрийн цагаар гэрээр болон СЭМТөв дээр эмчилгээ, сувилгаа, оношлогоог хийж гүйцэтгэнэ.
5. Өдрийн эмчилгээг 0-5 насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай болон нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэнийг хамруулна.
6. Өдрийн эмчилгээнд оношийн ангилалд хамаарах өвчний гэрээр эмчилнэ.
7. Өдрийн эмчилгээний хийлгэх өдөр, дараалал, цаг товлох, эмчилгээ үргэлжлэх хугацааг зохицуулах асуудлыг эрүүл мэндийн төвийн дарга хариуцна.

Хоёр. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл

1. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх өрөө нь стандартын шаардлага хангасан байна. Үйлчилгээний өрөө нь 18мкв-аас доошгүй талбайтай, эмийн шүүгээ, сувилагчийн тэргэнцэр, угаалтууртай байна
2. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхдээ халдвар хамгаалал, хяналтын журмыг баримтлан ажиллана.
3. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээнд халдвараас сэргийлэх хяналтын баг, дотоод хяналтын баг хяналт тавин ажиллана.
4. Өдрийн эмчилгээгээр үйлчлүүлэгчийг эмч өөрөө хариуцан үзэж, өвчний түүхийг хөтөлнө.
5. Өдрийн эмчилгээнд сувилагч нар түгээмэл үйлдлийн стандартыг мөрдөн, сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
6. Өдрийн эмчилгээний сувилагчид 1 өдөрт 3 үйлчлүүлэгч ноогдохоор тооцож ажиллана.
7. Өдрийн эмчилгээ, үйлчилгээг холбогдох эмнэлзүйн стандарт, удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчний түүх сувилгаа, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээний картанд тэмдэглэнэ.
8. Эмчилгээ, үйлчилгээний нэг удаад үргэлжлэх хугацаа нь 4 цагаас хэтрэхгүй байх
9. Эмчилгээний дараа өвчтний биеийн байдлыг асууж лавлах, зөвөлгөө өгөх, холбоо барихад зориулсан утас цахим сүлжээгээр хангасан байна.
10. Өдрийн эмчилгээний өрөөг яаралтай тусламжийн эм багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байна.

- 11 Үйлчлүүлэгчид эмнэлгийн хуудсыг эмчлүүлсэн хоногоор бодож, өвчний түүхийг хааснаас хойш ажлын 5 хоногт багтаан олгоно.
- 12 Өдрийн эмчилгээ, эмчилгээний зохицуулалтыг чирэгдэлгүй, эмнэлгийн мэргэжилтний ачааллыг оновчтой зөв зохион байгуулан бусад тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохицуулана.

Гурав. Өдрийн эмчилгээ үйлчилгээнд хамруулах заалт

Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд дараах шаардлагыг үндэслэн өдрийн эмчилгээнд хамруулна. Үүнд:

1. Өвчтөний онош шинжилгээ, эмнэлзүйгээр батлагдсан байх.
2. Өвчтөний өвчин эмгэг нь амь насанд аюул учруулахгүй байх.
3. Өдрөөр хийгдэх эмчилгээ, үйлчилгээний дараа ажиглалтын хугацаа дуусахад өвчтөн гэртээ харих бүрэн чадамжтай байх.
4. Бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний явцад байнгын асран хамгаалагчтай байх.
5. Өвчтөн хэвтрийн дэглэм сахих заалтгүй байх.
6. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний давтамж нь 10 өдрөөс хэтрэхгүй, улиралд 1-ээс илүүгүй байх.
7. Өвчтөн болон асран хамгаалагч нь холбоо барих утастай байх.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцан
үзүүлэх өдрийн эмчилгээнд хамаарах оношийн ангилал**

№	Бүлгийн нэр	ОХБ- №	Онош	Өвчний олон улсын 10 дугаар ангилал
1	Мэдрэлийн эмгэг	6	Ердийн мигрень, толгойн өвдөлт	G43.0, G44
2	Чих хамар хоолойн эмгэг	16	Цочмог болон архаг фарингит, тонзилит, трахейт, ларингит, бронхит	J02-J08, J20 J30-J32 J35, J37
3	Амьсгалын замын эмгэг	19, 20	Үүсгэгч нь тодорхой томуугийн болон бактерт пневмони /шинжилгээгээр оношийг баталсан байх/	J10-J11, J13, J15, J20- J21
4	Зүрх судасны тогтолцооны эмгэг	31	Артерийн даралт ихсэх өвчний хөнгөн хэлбэр	I10-I15
5	Бөөр, шээсний замын тогтолцооны эмгэг	82	Архаг пиелонефрит, хурц болон архаг цистит	N11, N30
6	Хоол боловсруулах замын эмгэг	49, 53, 59	Гастрит, дуоденит, диспепси, Халдварт бус гастроэнтерит ба колит, суулгалт өвчин	K29, K30, K52.9
7	Артрит, холбох эдийн эмгэг	69	Хэрлэг төст артрит /M05,M06/ Артроз /M15-M18/	M05, M06 M15-M18